ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 05 өдөр Дугаар А/58 Арвайхээр сум

А.Нямыг Ө.Дэлгэрмаа, Ө.Цогзолмаа нарын асран хамгаалагчаар тогтоох тухай

Гэр бүлийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1.1 дэх заалт, 72 дугаар зүйлийн 72.1, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүсэлт ирүүлсний дагуу Ноён 10 дугаар багийн иргэн Өлзийбаярын Дэлгэрмаа, Өлзийбаярын Цогзолмаа нарын асран хамгаалагчаар Адъяасүрэнгийн Нямыг тогтоосугай.

2.Асрамж дэмжлэгтээ байгаа хүнийг хоол хүнс, орон байраар хангах эрх ашиг сонирхлыг нь хамгаалах мөнгөн хөрөнгө, үнэт зүйл, үнэт цаас бусад баримт бичгийг банканд хадгалуулах, үл хөдлөх, мал, банканд хадгалуулсан мөнгөн хадгаламж, бусад үнэт зүйлийг өөрсдөд нь зориулан зарцуулж, хүлээсэн үүргийнхээ талаар сумын Засаг даргад жил бүр тайлагнаж байхыг асран хамгаалагчид үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарснаар сумын Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/35 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

4.Асрамж дэмжлэгт байгаа хүнд хувийн хэрэг нээж асран хамгаалагчтай гэрээ байгуулж биелэлтэд хяналт тавьж ажиллахыг сум хариуцсан Улсын бүртгэгч (Г.Шагдарсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.ГАНБАТ

D:2024/Alban bichig/Zahiramj-2024

62241139